

What to Bring to Hospital when Having a Baby

Эмнэлэгт төрөхөөр очихдоо юу авч очих вэ?

Mongolian

September 2018

Энэхүү жагсаалтад та хүүхдээ төрүүлэхээр эмнэлэгт авч очвол зохих зүйлсийг санал болгон бичсэн байгаа болно.

Машиндаа

- 2ш хуучин цэвэрхэн алчуур
- Бөөлжих хэрэгтэй болсон үед хэрэглэх пластик сав

Зориулалтын, албан ёсоор баталгаажуулагдсан хүүхдийн суудлыг машиндаа бэхэлсэн байх

Таны авчрах зүйлс

- Таны төрөх бүртгэлийн карт
- Медикер карт
- Хэрэв хувийн эрүүл мэндийн даатгалтай бол даатгалын тань мэдээлэл
- Төрөх үед өмсөх хувцас – том пудволк эсвэл унтлаганы хувцас
- Унтлаганы хувцас, халад
- Өдөр өмсөх биед тохиромжтой сул хувцас
- Биед тохиромжтой гутал
- Дотуур хувцас /хүүхэд хөхүүлэхэд зориулагдсан хөхний даруулга 2ш/
- Төрсөн эхчүүдэд зориулсан эмэгтэйчүүдийн хэрэглэл
- Хөхөндөө тавих жижиг алчуур
- Ариун цэврийн хэрэгслүүд – саван, шүдний сойз, дезодорант, шампунь, сам, нүүрний алчуур
- Уруул чийгшүүлэгч
- Үс хатаагч
- Амандаа хүлхэх амттан/чихэр
- Утас цэнэглэгч

Нөхөр болон танд туслах хүмүүс авчрах зүйлс

- Хоол хүнс, уух зүйлс
- Биед тохиромжтой сул хувцас, ноосон цамц. Учир нь эмнэлэг дотор сэрүүхэн байдаг
- Үзэг цаас
- Усны хувцас
- Бичлэг хийх боломжтой утас, видео камер, цэнэглэгч

Хүүхэддээ зориулж

- Хүүхдийн живх /өдөрт 8-10 удаа хэрэглэхээр/
- Хүүхдийн нойтон салфетка
- Хүүхдээ хүүхдийн сүүгээр хооллоно гэж төлөвлөсөн бол хүүхдийн хүүурай сүү угжны хамт
- Хүүхэд эмнэлгээс гарахад өмсгөх хувцас

Англи хэлээр ойлголцоход тусламж хэрэгтэй байгаа бол мэргэжлийн орчуулагчийн үйлчилгээг авч болно. Орчуулгын үйлчилгээ үнэгүй бөгөөд мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй байдаг. Орчуулагч хэрэгтэй бол эмнэлгийн ажилчдаас хүсч болно. Эсвэл 131 450 дугаараар Орчуулгын алба (TIS)-тай холбогдоорой.

Холбоо барих утас

Нэр: _____ Утас: _____